# “Логистик менежментийн тулгамдсан асуудал” сэдэвт Хэлэлцvvлэг-хуралд урьж байна

2013 оны 5-р сарын 09, Пvрэв гариг, 05:58

“Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн Танхим”, “Монголын Логистикийн Холбоо”, ШУТИС-КТМС-ээс хамтран **“Логистик менежментийн тулгамдсан асуудал”** сэдвээр хэлэлцvvлэг-хурлыг анх удаа бизнес эрхлэгчид, судлаачид, төрийн бус байгууллагууд болон ЗТЯ зэрэг холбогдох төрийн байгууллагуудын дунд нээлттэй зохион байгуулах гэж байна. Та бvхнийг идэвхитэй оролцохыг урьж байна. /Хурлын хөтөлбөрийг хавсаргав/

Ингэснээр олон улсын, орон нутгийн болон дотоод тээвэрлэлтэд гарч байгаа бэрхшээл, цаашид авбал зохих арга хэмжээ, хууль эрх зvйн орчин, бизнесийн тодийгvй төрийн байгууллагуудын логистик, менежментийн асуудлуудыг зөв удирдан зохион байгуулснаар гарах vр дvнгийн талаар онол практик дээр vндэслэн хэлэлцэж ач холбогдол бvхий судалгааны шинэ бvтээл, vзэл санааг хөгжvvлэх, олон нийтэд тvгээн дэлгэрvvлэх, харилцан санаа бодлоо чөлөөтэй солилцох, судлаач, багш, оюутны эрдэм шинжилгээ, судалгаа, бизнес эрхлэгчдийн тослийг дэмжихэд чиглэгдэнэ.

Уг хурлын хvрээнд “БИЗНЕСИЙН БАЙГУУЛЛАГА ДАХЬ ЛОГИСТИК МЕНЕЖМЕНТИЙН АСУУДАЛ” сэдэвт эрдэм шинжилгээний шилдэг огvvллийн уралдааныг 2 vе шаттайгаар зарлаж байгаа болно.

**Хаана:** Хэлэлцvvлэг - хурал МҮХАҮТ-ын vзэсгэлэнгийн их танхимд **2013 оны 5 сарын 31-ны 09:00-18:00**
цагт

**Бvртгэл:** 2013 оны 5 сарын 30 хvртэл бvртгэж урилга, мандат олгоно.

**Бvртгэлийг:**

МҮХАҮТ-ын Зураасан код, логистикийн хэлтэс
Мэргэжилтэн Г.Ганчимэг
**Харилцах хаяг:** 313411, 88008290, 99019141
**Цахим шуудан:** ganchimeg@mongolchamber.mn